



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

0

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	/төгрөгөөр/.....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	/төгрөгөөр/5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	/төгрөгөөр/.....6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	/төгрөгөөр/8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
3.2 Зөвлөмж.....	14
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЛХАГВАБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар насжилт өндөртэй авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, төсвийг тогтоосон норматив зардлаас хэтрүүлэн зарцуулсан, цалинг зөрүүтэй тооцож олгосон зэрэг 157,052.5 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 67,622.9 мянган төгрөгөөр их байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.2, 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6-д заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад төсвөөс олгох санхүүжилтийг 2,690.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өмнөх оноос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, зардлууд өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг

4826050255

санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 29 зорилт, 108 арга хэмжээг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,518,446.31	2,947,406.31
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	21,518,446.31	2,947,406.31
3121	Төгрөг	21,518,446.31	2,947,406.31
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	21,518,446.31	2,947,406.31
33	АВЛАГА	164,074,124.00	180,498,368.98
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	230,000.00	
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,488,980.00	18,144,440.00
335	Бусад авлага	157,355,144.00	162,353,928.98
3351	Байгууллагаас авах авлага	63,910,068.00	68,908,852.98
3352	Хувь хүмүүсээс авах авлага	93,445,076.00	93,445,076.00
35	БАРАА МАТЕРИАЛ	464,581,108.92	1,478,806,171.93
351	Түүхий эд материал	108,480.00	1,608,480.00
3511	Тусгай зориулалттай материал	108,480.00	1,608,480.00
354	Хангамжийн материал	464,472,628.92	1,477,197,691.93
3541	Бичиг хэргийн материал	3,487,885.00	966,825.00
3542	Аж ахуйн материал	390,634,885.92	1,445,503,107.93
3543	Сэлбэг хэрэгсэл	17,085,000.00	
3544	Түлш, шатах тослох материал	11,066,100.00	1,111,659.00
3545	Барилгын засварын материал	38,017,290.00	29,616,100.00
3546	Хүнсний материал	4,181,468.00	
36	НӨӨЦИЙН БАРАА	5,970,000.00	5,970,000.00
363	Тэжээлийн нөөц	5,970,000.00	5,970,000.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	656,143,679.23	1,668,221,947.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,211,745,385.14	12,917,935,273.83
392	Биет хөрөнгө	8,818,306,288.30	9,527,734,505.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,323,413,475.61	9,323,413,475.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,397,557,252.04)	(1,547,943,969.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	605,850,000.00	605,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(504,066,666.58)	(521,799,999.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,609,252,378.99	2,221,358,570.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,133,611,170.70)	(874,143,776.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	552,247,160.91	581,518,510.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(392,391,272.98)	(393,467,362.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	340,527,900.00	340,527,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(185,358,264.91)	(207,578,842.99)
393	Биет бус хөрөнгө	3,393,439,096.84	3,390,200,768.68
39301	Програм хангамж	120,557,725.00	120,557,725.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(90,459,428.16)	(93,697,756.32)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,363,340,800.00	3,363,340,800.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,211,745,385.14	12,917,935,273.83
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,867,889,064.37	14,586,157,221.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	39,785,119.57	67,992,838.75
413	Өглөг	39,785,119.57	67,992,838.75
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	2,100,512.57	2,189,868.75
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	37,684,607.00	45,573,470.00
4136	Бусад өглөг		20,229,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг		20,229,500.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	39,785,119.57	67,992,838.75
51	Засгийн газрын хувь оролцоо	12,828,103,944.80	14,518,164,382.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,556,641,311.61	5,556,641,311.61
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	5,556,641,311.61	5,556,641,311.61
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	4,449,126,882.98	6,139,187,320.48
5121	Өмнөх үеийн үр дүн	4,449,126,882.98	4,407,476,163.98
5122	Тайлант үеийн үр дүн		1,731,711,156.50

513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,822,335,750.21	2,822,335,750.21
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,828,103,944.80	14,518,164,382.30
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,867,889,064.37	14,586,157,221.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,035,758,480.20	8,725,874,929.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	405,291,480.20	352,167,829.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	294,052,220.00	245,240,143.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,844,692.00	58,187,889.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,394,568.20	48,739,797.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,630,467,000.00	8,373,707,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,630,467,000.00	8,208,959,900.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		164,747,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	848,807,605.31	2,002,671,287.00
120	Нийтлэг татварын бус орлого	848,807,605.31	2,002,671,287.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,513,941.50	18,671,981.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,500.00	30,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,274,441.50	18,641,981.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	343,622,165.91	875,930,801.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	472,671,497.90	1,108,068,505.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,884,566,085.51	10,728,546,216.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,597,903,940.26	8,942,965,593.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,006,017,724.59	8,264,925,325.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,472,044,520.63	3,052,015,157.65
210101	Үндсэн цалин	1,287,234,381.63	1,456,661,030.28
210102	Нэмэгдэл	945,828,739.00	1,244,397,914.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,565,000.00	185,308,482.64
210104	Урамшуулал	160,416,400.00	165,647,730.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	284,237,810.44	348,479,392.50
210201	Тэтгэврийн даатгал	193,304,269.00	233,812,109.56
210202	Тэтгэмжийн даатгал	23,100,433.26	28,404,010.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,533,243.21	16,328,665.90
210204	Ажилгүйдлийн даатгал	10,594,152.16	13,069,496.40
210205	Эрүүл мэндийн даатгал	45,705,712.81	56,865,110.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	295,453,009.87	300,980,869.72
210301	Гэрэл, цахилгаан	32,971,237.99	47,246,662.22
210302	Түлш, халаалт	244,332,905.80	240,032,241.00
210303	Цэвэр, бохир ус	18,148,866.08	13,701,966.50
2104	Хангамж, бараа материалын зардал	270,530,902.36	328,771,008.99
210401	Бичиг хэрэг	18,688,310.00	21,856,775.00
210402	Тээвэр, шатахуун	121,691,851.20	98,376,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,534,162.76	20,249,527.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,320.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,455,258.40	187,538,256.99
2105	Нормативт зардал		3,910,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		3,910,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	145,624,550.00	272,566,583.18

210601	Багаж, техник, хэрэгсэл		6,671,225.00
210604	Урсгал засвар	145,624,550.00	265,895,358.18
2107	Томилолт, зочны зардал	92,386,852.00	108,891,000.00
210702	Дотоод албан томилолт	92,386,852.00	108,891,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,928,735.20	1,663,687,180.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,317,000.00	1,643,375,310.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,251,250.00	10,207,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	461,061.60	606,155.20
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	145,349.60	271,851.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,872,000.00	8,647,989.00
210807	Газрын төлбөр	882,074.00	577,975.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,391,811,344.09	2,185,624,133.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,721,050,730.00	1,837,920,394.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,734,588.00	17,506,089.01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	636,026,026.09	330,197,650.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	591,886,215.67	678,040,267.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	543,871,465.00	89,622,351.44
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,982,400.00	13,860,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,520,386.00	12,113,589.42
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	185,536,072.00	7,305,750.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	247,832,607.00	56,343,012.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48,014,750.67	588,417,916.04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,014,750.67	588,417,916.04
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,597,903,940.26	8,942,965,593.21
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	286,662,145.25	1,785,580,623.33
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	410,979,982.90	53,869,466.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,000,000.00	1,016,536.83
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	6,480,000.00	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	398,499,982.90	52,852,930.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(410,979,982.90)	(53,869,466.83)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(124,317,837.65)	1,731,711,156.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,067,066,421.70	8,732,891,450.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,307,941.50	7,016,521.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,307,941.50	7,016,521.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,307,941.50	7,016,521.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,500.00	30,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,068,441.50	6,986,521.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,035,758,480.20	8,725,874,929.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	405,291,480.20	352,167,829.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	294,052,220.00	245,240,143.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,844,692.00	58,187,889.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,394,568.20	48,739,797.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,630,467,000.00	8,373,707,100.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,630,467,000.00	8,208,959,900.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		164,747,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,971,244,356.20	8,609,455,890.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,971,244,356.20	8,609,455,890.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,373,058,140.53	7,875,678,619.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,469,818,620.06	3,051,939,120.22
210101	Үндсэн цалин	1,285,008,481.06	1,456,661,030.28
210102	Нэмэгдэл	945,828,739.00	1,246,268,427.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	78,565,000.00	185,308,482.64
210104	Урамшуулал	160,416,400.00	163,701,180.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	284,237,810.44	348,236,073.75
210201	Тэтгэврийн даатгал	193,304,269.00	233,646,652.81
210202	Тэтгэмжийн даатгал	23,100,433.26	28,384,545.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,533,243.21	16,318,933.15
210204	Ажилгүйдлийн даатгал	10,594,152.16	13,059,763.65
210205	Эрүүл мэндийн даатгал	45,705,712.81	56,826,179.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	295,603,009.87	331,144,666.72
210301	Гэрэл, цахилгаан	32,971,237.99	47,246,662.22
210302	Түлш, халаалт	244,332,905.80	270,196,038.00
210303	Цэвэр, бохир ус	18,298,866.08	13,701,966.50
2104	Хангамж, бараа материалын зардал	204,930,454.96	158,300,626.00
210401	Бичиг хэрэг	18,223,420.00	19,170,620.00
210402	Тээвэр, шатахуун	123,307,547.20	77,161,384.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,534,162.76	20,249,527.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,320.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	51,704,005.00	40,969,095.00
2105	Нормативт зардал		3,910,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		3,910,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	167,733,450.00	254,554,068.18
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,806,900.00
210604	Урсгал засвар	167,733,450.00	238,747,168.18
2107	Томилолт, зочны зардал	92,556,852.00	90,006,200.00
210702	Дотоод албан томилолт	92,556,852.00	90,006,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,758,595.20	1,717,796,380.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,146,860.00	1,697,484,510.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,251,250.00	10,207,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	496,411.20	606,155.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,872,000.00	8,647,989.00
210807	Газрын төлбөр	882,074.00	684,826.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,801,419,348.00	1,919,791,484.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,762,684,760.00	1,906,285,395.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,734,588.00	13,506,089.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	598,186,215.67	733,777,271.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	550,171,465.00	88,409,851.44
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,982,400.00	13,860,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,520,386.00	12,113,589.42
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	185,536,072.00	7,305,750.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	254,132,607.00	55,130,512.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	48,014,750.67	645,367,420.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	48,014,750.67	645,367,420.02

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	95,822,065.50	123,435,560.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	95,681,040.00	142,006,600.00
	Дотоод эх үүсвэрээр	95,681,040.00	142,006,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	95,681,040.00	142,006,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(95,681,040.00)	(142,006,600.00)
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	141,025.50	(18,571,040.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,518,446.31
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,947,406.31

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,556,641,311.61	2,822,335,750.21	4,449,126,882.98	12,828,103,944.80
2					
3					
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,556,641,311.61	2,822,335,750.21	4,449,126,882.98	12,828,103,944.80
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-41,650,719.00	-41,650,719.00
6	Тайлант үеийн үр дүн			1,731,711,156.50	1,731,711,156.50
7				
8	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,556,641,311.61	2,822,335,750.21	6,139,187,320.48	14,518,164,382.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	8,373,707,100.00	7,785,289,183.96	588,417,916.04
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,373,707,100.00	7,785,289,183.96	588,417,916.04
132001	Орон нутгийн төсвөөс	8,208,959,900.00	7,620,541,983.96	588,417,916.04
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	164,747,200.00	164,747,200.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,000,000.00	7,016,521.00	(16,521.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		30,000.00	(30,000.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,986,521.00	(6,986,521.00)
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,380,707,100.00	7,792,305,704.96	588,401,395.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,380,707,100.00	7,792,305,704.96	588,401,395.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,268,115,400.00	7,703,895,853.52	564,219,546.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,297,313,700.00	3,012,965,648.22	284,348,051.78
210101	Үндсэн цалин	1,430,475,200.00	1,430,475,148.28	51.72
210102	Нэмэгдэл	1,416,480,900.00	1,242,080,837.30	174,400,062.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	187,212,000.00	176,708,482.64	10,503,517.36

210104	Урамшуулал	263,145,600.00	163,701,180.00	99,444,420.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	428,114,000.00	343,006,079.20	85,107,920.80
210201	Тэтгэврийн даатгал	289,203,900.00	230,318,550.81	58,885,349.19
210202	Тэтгэмжийн даатгал	34,727,500.00	27,993,003.62	6,734,496.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,363,800.00	15,815,149.45	1,548,650.55
210204	Ажилгүйдлийн даатгал	17,363,800.00	12,836,279.03	4,527,520.97
210205	Эрүүл мэндийн даатгал	69,455,000.00	56,043,096.29	13,411,903.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	380,187,000.00	331,144,666.72	49,042,333.28
210301	Гэрэл, цахилгаан	56,825,400.00	47,246,662.22	9,578,737.78
210302	Түлш, халаалт	300,161,600.00	270,196,038.00	29,965,562.00
210303	Цэвэр, бохир ус	23,200,000.00	13,701,966.50	9,498,033.50
2104	Хангамж, бараа материалын зардал	160,059,800.00	137,318,000.00	22,741,800.00
210401	Бичиг хэрэг	18,191,200.00	18,191,120.00	80
210402	Тээвэр, шатахуун	78,917,000.00	68,630,763.00	10,286,237.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,642,800.00	17,588,877.00	1,053,923.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000.00	750,000.00	3,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,808,800.00	32,157,240.00	7,651,560.00
2105	Нормативт зардал	4,500,000.00	2,953,000.00	1,547,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	2,953,000.00	1,547,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361,563,400.00	319,608,668.18	41,954,731.82
210601	Багаж, техник, хэрэгсэл	89,523,400.00	69,511,500.00	20,011,900.00
210602	Тавилга	16,000,000.00	11,350,000.00	4,650,000.00
210604	Урсгал засвар	256,040,000.00	238,747,168.18	17,292,831.82
2107	Томилолт, зочны зардал	95,770,000.00	90,006,200.00	5,763,800.00
210702	Дотоод албан томилолт	95,770,000.00	90,006,200.00	5,763,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,764,387,900.00	1,738,002,556.20	26,385,343.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,743,382,100.00	1,718,698,786.00	24,683,314.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,274,800.00	9,274,800.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,087,900.00	539,655.20	548,244.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	156,500.00	156,500.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,676,600.00	8,647,989.00	1,028,611.00
210807	Газрын төлбөр	810,000.00	684,826.00	125,174.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,776,219,600.00	1,728,891,035.00	47,328,565.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,763,259,600.00	1,718,411,535.00	44,848,065.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,960,000.00	10,479,500.00	2,480,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,591,700.00	88,409,851.44	24,181,848.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,591,700.00	88,409,851.44	24,181,848.56
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,860,000.00	13,860,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,193,700.00	12,113,589.42	80,110.58
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,538,000.00	7,305,750.02	9,232,249.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,000,000.00	55,130,512.00	14,869,488.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	8,380,707,100.00	7,792,305,704.96	588,401,395.04

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,167,829.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	352,167,829.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	245,240,143.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,187,889.04
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,739,797.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	352,167,829.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,167,829.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,218,325.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,973,472.00
210101	Үндсэн цалин	26,185,882.00
210102	Нэмэгдэл	4,187,590.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,600,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,229,994.55
210201	Тэтгэврийн даатгал	3,328,102.00
210202	Тэтгэмжийн даатгал	391,541.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	503,783.70
210204	Ажилгүйдлийн даатгал	223,484.62
210205	Эрүүл мэндийн даатгал	783,082.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	
2104	Хангамж, бараа материалын зардал	20,982,626.00
210401	Бичиг хэрэг	979,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,530,621.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,660,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,811,855.00
2105	Нормативт зардал	957,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	957,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,275,824.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,267,724.00
210803	Даатгалын үйлчилгээ	933,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	8,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	222,799,409.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	219,772,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,026,589.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,949,503.98
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	56,949,503.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,949,503.98
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	352,167,829.54

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,574,156.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 28,180.8 мянган төгрөгийн 1 зөрчлийг аудитын явцад залруулан, 222,319.2 мянган төгрөгийн 8 зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага, 3,590.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,321,423.5 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа:

1. Зарцуулсан 28,180.0 мянган төгрөгийн бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах) заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад бүрэн залруулсан.

Залруулагдаагүй алдаа:

3.1 Төлбөрийн акт

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд хүндэтгэлийн хүлээн авалт хийхдээ тогтоосон норматив зардлаас 3,590.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 85 дугаар тогтоолын "Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын норматив"-ын 1.1-т (*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын хүндэтгэлийн хүлээн авалтыг нэг хүнд 80,000 төгрөг хүртэл*) заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Байгууллага болон хувь хүнээс авах түрээсийн 65,266.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг;
2. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхдээ холбогдох хууль, журмыг зөрчин, цалинг 419.6 мянган төгрөгөөр илүү тогтоосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1-т (*Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно*) заасныг;
3. Цалинтай чөлөө олгосон албан хаагчдын цалинг 1,923.6 мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-т (*"анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог*), 13.1-д (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*) заасныг;
4. Төрийн одон, салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан албан хаагчдад 1,900.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал дагалдуулж олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 1.7-д (*Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй*) заасныг;
5. Албан тушаалын тодорхойлолтгүй ажлын байранд хүн авч ажиллуулан 5,628.0 мянган төгрөгийн цалин олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т (*Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана*), 49.1.1-т (*ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг*) заасныг;
6. Албан хаагчдад хуулиар олгосон ээлжийн амралтыг биеэр бүтэн эдлүүлэлгүй ээлжийн амралтын цалинг 40,823.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн олгож, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.3-т (*батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*) заасныг;

7. Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад 2,233.0 мянган төгрөгийн хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) заасныг;
8. Санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй 102,768.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,321,423.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-т (*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*) заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх талаар эрх бүхий байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдах боломжгүй 222,319.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 157,052.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 67,622.9 мянган төгрөгөөр их тул “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зарцуулсан бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан.	1	28,180.8			1	28,180.8	1	28,180.8		
Дүн	1	28,180.8			1	28,180.8	1	28,180.8		

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллага болон хувь хүнээс авах түрээсийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	65,266.8			1	65,266.8				
Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхдээ холбогдох хууль, журмыг зөрчин, цалинг илүү тогтоосон.	1	419.6			1	419.6				
Цалинтай чөлөө олгосон албан хаагчдын цалинг илүү тооцож, олгосон.	1	1,923.7			1	1,923.7				
Төрийн одон, салбарын тэргүүний ажилтнаар шагнагдсан албан хаагчдад дагалдах мөнгөн шагнал олгосон.	1	1,900.0			1	1,900.0				
Албан тушаалын тодорхойлолтгүй ажлын байранд хүн авч ажиллуулсан.	1	5,628.0			1	5,628.0				
Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд хүндэтгэлийн хүлээн авалт хийхдээ тогтоосон норматив зардлаас илүү зарцуулсан.	1	3,590.0	1	3,590.0						
Албан хаагчдад хуулиар олгосон ээлжийн амралтыг биеэр бүтэн эдлүүлэлгүй ээлжийн амралтын цалинг нэмэгдүүлэн олгож, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	40,823.1			1	40,823.1				

Санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	102,768.2			1	102,768.2				
Дүн	8	222,319.2	1	3,590.0	8	220,962.2				

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр албан хаагчдад хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	2,233.0			1	2,233.0				
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.	1	1,321,423.5					1	1,321,423.5		
Дүн	2	1,323,656.5			1	2,233.0	1	1,321,423.5		